



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/499

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Аймгийн төсөв батлах тухай” 8/04 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Санхүүчдийг чадавхжуулах хөтөлбөр”-ийн дагуу санхүү, төрийн сангийн хэлтсийн цахим тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах арга хэмжээнд зарцуулах 6,7 сая төгрөг /Зургаан сая долоон зуун мянган/-ийн төсвийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2. Үйл ажиллагаанд зарцуулах 6.7 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.8 дахь заалтын “Нягтлан бодох санхүүчдийг чадавхжуулах хөтөлбөр”-өөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны  
08 дугаар сарын 01-ний өдрийн  
А/499 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭСТ АВАХ  
ЦАХИМ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

ДД	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөгөөр/	Нийт үнэ /төгрөгөөр/
1	Компьютер	ш	1	1700000.00	1700000.00
2	Компьютерийн дэлгэц	ш	1	400000.00	400000.00
3	Нөүтбүүк	ш	2	2300000.00	4600000.00
	Дүн				6700000.00

.....оОо.....